

“Миг даатгал” ХХК-д иргэний агаарын хөлгийн даатгалын  
хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл  
нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Даатгалын тухай хуулийн 13.1.2, Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.23 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Миг даатгал” ХХК-д даатгалын дараах хэлбэрээр ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж олгосугай. Үүнд:

1/ Иргэний агаарын хөлгийн (1.2.8).

2. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т, “Миг даатгал” ХХК-ийн ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан даатгалын хэлбэрийг нэмж бүртгэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ